ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ТӨМӨР-ОЧИРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /хүрээгүй бол тайлбар/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжинэ. | | | | | | | |
| Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх | | | | | | | |
| 1 | Гаалийн байгууллагын 2023 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланд хяналт - шинжилгээ, үнэлгээ хийж, Сангийн яаманд бүтэн жилээр тайлагнах. | Гаалийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээгээр | Гаалийн байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг СЯ-нд хүргүүлж **92.28** хувиар үнэлэгдсэн. | -Гаалийн байгууллагаас хэрэгжүүлсэн эрх зүйн акт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сангийн сайдын шийдвэр зэрэг эрх зүйн актуудын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Сангийн Яаманд хугацаанд нь тайлагнана. | 1.Гаалийн ерөнхий газрын 2023 оны үйл ажиллагааны тайланг ЗУГ болон ЗББНДБ-аас нэгтгэсэн нийт 9 бүлэг, 312 хуудас хавсралт тайланд ХШҮ хийж, Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт 2024 оны 01 дугаар сарын 30-ны өдрийн 01-4/397 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2.Сангийн яамнаас ГБ-ын 2023 оны үйл ажиллагааг **88.2** хувиар үнэлж ирүүлсэн ХШҮ-ний тайланд дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр ажил сайжруулах чиглэлийг ГЕГ-ын ЗББНДБ-дад 40 дугаарын дотоод зурвасаар хүргүүлэв. | 01.01<br>06.25 | 88.2 |
| 2 | ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын 2024 оны шалгуур үзүүлэлтийн биелэлтэд ХШҮ хийж, нэгдсэн тайланг ЗЗХ-нд хэлэлцүүлэх. | Үйл ажиллагаа | -ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын 2023 оны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлтэд бүтэн жилээр ХШҮ хийж ЗББНДБ 86.25 харьяа гаалийн газар, хороод 85.26 үнэлэгдсэн. | -ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын 2024 оны шалгуур үзүүлэлтийн биелэлтэд хагас жилээр ХШҮ хийж, нэгдсэн тайланг ГЕГ-ын Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.(II улирал) | 1.Гаалийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 16 зүйл 138 хэсэг, 185 заалтын хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд 91 хувьтай буюу **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж дүгнэв. Үүнд:<br>-1, 2, 3, 8, 9, 16, зүйл заалтын хэрэгжилт - 90.1 хувь<br>-4, 5, 6, 7, 10, 12, 14, 15, зүйл заалтын хэрэгжилт – 100 хувь<br>-11, 13, зүйл заалтын хэрэгжилт – 63 хувийн биелэлттэй байна. | 01.01<br>06.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - ГЕГ-ын нэгжүүдэд болон харьяа газар, хороодод ХШҮ-ний үр дүнгээр 251 зөвлөмжийг хугацаатай хүргүүлэн, биелэлтийг 82.01 хувьтай гэж дүгнэв.<br>-Гаалийн байгууллагын хэмжээнд 8 төсөл, 2 хөтөлбөр хэрэгжиж, ГЕГ-ын 8 нэгж, зарим нэгжийн албан хаагчид сургалтад хамрагдсанаар Бүрэн хэрэгжсэн хэмээн дүгнэв. Цаашид ГЕГ-ын хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн талаар нэгдсэн бүртгэл, тайлан зохион байгуулалтын бүтцийн аль нэг нэгж дээр байхгүй, хэрэгжүүлэх зорилго, ажил нь тодорхой бус, мөн уг төсөл хөтөлбөрийн хүрээнд хүрэх зорилго, хүрсэн үр дүн тодорхой бус байна. Иймд гаалийн байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй аян, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд журам, аргачлалын дагуу хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, үр дүнг нэгтгэн шийдвэрлүүлэх чиг үүргийн биелэлтийг үр | - ГЕГ-ын нэгжүүдэд болон харьяа газар, хороодод ХШҮ-ний үр дүнгээр хүргүүлсэн зөвлөмжийг хугацаатай хүргүүлэн, биелэлтийг дүгнэнэ.<br>- Гаалийн байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй аян төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ.<br>(I улирал)<br>-ГЕГ-ын ЗББНДБ, харьяа ГГХ-дын үйл ажиллагаанд улирал бүр явцын ХШҮ хийж, үр дүнгээр гарсан зөвлөмжийг Шуурхай хуралдаанд танилцуулж, биелэлтийг хангуулж дүгнэнэ. (I-II улирал)<br>Үүнд:<br>1.Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийн ХШҮ,<br>2.Ажлын хэсгийн үр дүнд ХШҮ хийх,<br>3.СТ 2021-2023 оны буюу эхний 3 жилийн хэрэгжилтийн ХШҮ,<br>4.УХШИГГ-т өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийн ХШҮ, | 2.Нийт 31 Ажлын хэсгийн үр дүнд ХШҮ хийв. ГЕГ-ын нэгжүүдээс ХБГ-7, ТТГ-1, СХОГ-6, ГТЛ-9, ХЦХ-1, ХНХ-4, ХХ-2, СДШХ-1, ЭУХ-5, БДШГ-1, ХШҮДАГ-2, СТ-2, ХНТ-4 удаагийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан байна. Нийт ажлын хэсгийн тайлан гаргасан байдлыг үзэхэд өмнөх жилүүдэд хэрэгжин үргэлжилж буй Гаалийн шинэчлэл төслийн хүрээний АХ-үүд тайлан бичдэггүй, үр дүнг тооцоогүй мөн Гаалийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн АХ-ийн үйл ажиллагаа ямар түвшинд байгаа талаар тайлан гаргаагүй, Гаалийн байгууллагын хүний нөөцийн хөтөлбөрийг боловсруулах АХ-ийн үйл ажиллагааны хэрэгжилт дутуу, Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах болон Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөрийн төсөл боловсруулах АХ-ийн тайлан гаргаагүйгээс ямар үр дүнд хүрснийг үнэлэх боломжгүй байна. Харин бусад чиглэлээрх АХ-ийн тайлангууд дэлгэрэнгүй, цаашид авах арга хэмжээний саналыг тусгасан үр дүнтэй байсан байна. Харьяа гаалийн газар, хороодод томилолтоор ажилласан Ажлын хэсгийн гишүүдийн зардал ГЕГ-ын нийт томилолтын зардлын 50 орчим хувийг эзэлсэн байна.<br>3. Гаалийн байгууллагын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх 4 зорилтын хүрээнд төлөвлөсөн арга | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дүнтэй, чанартай гүйцэтгэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:<br>-Гаалийн байгууллагын хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгдсэн бүртгэлтэй байх.<br>-Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага үр дүнг тодорхой тайлагнадаг байх.<br>-Гаалийн байгууллагын 2021-2022 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, **88.3** хувийн биелэлттэй гэж дүгнэсэн ба гарсан үр дүнгээр нийтлэг 2, тусгай 9 зөвлөмжийг 6 нэгжид буюу нийт 11 зөвлөмжийг хүргүүлсний дунд СТ-нд хорио цээрийн үйл ажиллагаатай уялдуулсан нэмэлт, өөрчлөлтийг хийж боловсруулсан төслийг Сангийн яаманд хүргүүлж, 3 дугаар сард шинэчлэн батлуулсан.<br>-Гаалийн байгууллагын шилэн дансны | 5.Шилэн дансны 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн ХШҮ,<br>6.Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн ХШҮ,<br>7.Лабораторийн дүгнэлтэд 2024 оны I дүгээр улирлын байдлаар хийсэн ХШҮ<br>8.2024 оны I дүгээр улирлын цахим бүрдүүлэлтэд хийсэн дүн шинжилгээ,<br>9.Үүрэг даалгаврын програмд хийсэн ХШҮ. | хэмжээнүүдийн биелэлтэд эхний гурван жилийн байдлаар явцын хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд **88.3 хувийн** биелэлттэй байгаа ба хэрэгжилт хангалтгүй, дутуу болон удаашралтай ажил, арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор дүгнэлт, зөвлөмж өгч, үр дүнг сайжруулахад анхаарав.<br>Стратеги төлөвлөгөөг:<br>• 2021 онд хэрэгжүүлэх 2;<br>• 2021-2022 онд хэрэгжүүлэх 3;<br>• 2021-2023 онд хэрэгжүүлэх 2;<br>• 2021-2024 онд хэрэгжүүлэх 29 дэд зорилт буюу нийтдээ 36 дэд зорилтын хүрээнд 2021 онд 142, 2022 онд 192, 2023 онд 146 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.<br>**Стратеги зорилт 1.1.** - ***87.1 хувь*** буюу ***"Тодорхой үр дүнд хүрсэн"*** гэж үнэлэгдсэн. Энэ зорилтын хүрээнд төлөвлөсөн ажлуудаас 3 нь хэрэгжилт дутуу буюу хангалтгүй үнэлэгдсэн.<br>**Стратеги зорилт 1.2.** - ***96.6 хувь*** буюу ***"Тодорхой үр дүнд хүрсэн"*** гэж үнэлэгдсэн.<br>**Стратеги зорилт 1.3.** - ***90 хувь*** буюу ***"Тодорхой үр дүнд хүрсэн"*** гэж үнэлэгдсэн.<br>**Стратеги зорилт 1.4.** - ***85.5 хувь*** буюу ***"Тодорхой үр дүнд хүрсэн"*** гэж үнэлэгдсэн. Тус зорилтын хүрээнд 8 ажлын хэрэгжилт 30-70 хувиар үнэлэгдсэнийг 2024 онд анхаарах шаардлагатай.<br>4.УХШИГГ-т хүргүүлсэн хугацаатай ҮД-ын биелэлтэд ХШҮ хийж, 81.25 хувиар үнэлж, цаашид анхаарах 5 зөвлөмжийг хүргүүлэв. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөтлөлтөд 2023 оны эхний хагас жилийн байдлаар ХШҮ хийж, 99.65 хувьтай гэж дүгнэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэв.<br>-УБГГ, ЗҮГГ-дад ГЕГ-ын чиг үүргийн шинжилгээг хийсэн шалган зааварчлах үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан үр дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зорилгоор хугацаат үүрэг даалгаврыг хүргүүлж, биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхийг ГЕГ-ын ХШҮДАГ-т Захиргааны зөвлөлийн хуралдаанаас даалгасан.<br>УБГГ-т өгсөн 24 үүрэг даалгаврыг ЗДАС программаар болон албан бичгээр хүргүүлэн, хяналт шинжилгээ, үнэлгээний эцсийн дүнг чанартай байлгах зорилгоор 4 удаа явцын тайланг гаргуулан, тухай бүр хяналт шинжилгээ хийж, 10 санал, зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Үүрэг даалгаврын биелэлтийг 81.08 хувьтай буюу Тодорхой | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үр дүнд хүрсэн гэж дүгнэв.<br>ЗҮГГ-т өгсөн 41 ҮД-ыг дээрхийн адил явцад нь хянан, 12 санал, зөвлөмжийг хүргүүлэн, биелэлтийг 83.06 хувь буюу Тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэв.<br>-КАЙС хөгжүүлэлтийн явцад буюу 2019-2023 онд хэрэгжсэн нийт 15 бүлэг 56 ажил үйлчилгээний 6 нь 95.8 хувь буюу Бүрэн хэрэгжсэн, 9 бүлэг ажил үйлчилгээ 78.3 хувь буюу Хэрэгжих шатанд гэж дүгнэв.<br>-МХНИнститутай хамтарсан ГЕГ-ын Ажлын хэсгээс гаргасан шийдвэрийн дагуу цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг хариуцан ажилласны үр дүнд "ГБ-ын Хүний нөөцийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр /2024-2029 он/"-ийг боловсруулсан.<br>-АТГ-ын ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд ХШҮ хийн, биелэлтийг 91 хувьтай буюу Бүрэн хэрэгжсэн гэж дүгнэв.<br>-ГЕГ-ын чиг үүргийн байдалд нийт 11 үзүүлэлтээр хяналт | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинжилгээ хийж, ГЕГ-ын ЗББНДБ-ын ачааллыг тооцсоны үндсэнд 6 ач холбогдлыг дурьдсан Гаалийн Цахим Төв гэсэн нэгж үүсгэх бүтцийн саналыг хүргүүлэв.<br>2022 онд ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал, ГЕГ-ын даргын тушаалаар батлагдсан “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд ажилласан тайланг гарган ирүүлэхийг ХШҮДАГ-аас Дотоод зурвас хүргүүлсэнд ГХШГ, ГБГ, ТОГ, ГЗТХБГ, БХГ, Хуулийн хэлтэс, ГХАХ, ГЕГ-ын дэргэдэх Гаалийн төв лаборатори, БДШГ, ЭНСТ зэрэг нийт 10 нэгжээс хариу ирүүлсэн. Нэгжүүдээс ирүүлсэн тайлангаас гаалийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, 88.8 хувиар дүгнэсэн тайланг танилцуулсан. | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Дотоод аудитын зорилгоор эрсдэлийн судалгаа шинжилгээ хийх | Үйл ажиллагаа | “Гаалийн байгууллагын эрсдэлд суурилсан дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө 2023-2025 он”-г боловсруулж, ГЕГ-ын даргын 2023.10.25-ны өдрийн А/502 дугаар тушаалаар батлуулав. Төлөвлөгөөг боловсруулахын тулд 2 төрлийн судалгааг хийж, нийт 7 шалгуур үзүүлэлтээр байгууллагын эрсдэлийн төлөвшлийн түвшинг тодорхойлов. Үүнд:<br>1. Төсвийн хэмжээ буюу 2022 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээ /сая.төгрөг/<br>2. Гүйцэтгэх удирдлагын тогтвортой байдал /Сүүлийн 5 жил/<br>3. Дотоод аудитын давтамж /2013-2022 он/<br>4. Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээ /2022 он/<br>5. Газар, хороодыг нэгжээс үнэлсэн үнэлгээ / 2022 он/<br>6. Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ | -Дотоод аудитын үр дүнг үндэслэн өмнөх 10 эрсдэлийн судалгааг баяжуулж,<br>- Шинээр 3 аудитын судалгааг хийнэ. | - Дотоод аудитын үр дүнгээр өмнөх онд хийгдсэн 10 эрсдэлийн судалгааг 2024 оны эхний хагас жилд хийгдсэн Барааны ангилал үнэлгээний хэлтэс, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитуудад ашиглаж судалгааг хийж ажлын баримтад тусгасан.<br>Сүүлийн хагас жилд хийгдэх Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын үйл ажиллагаанд хийх дотоод аудитын хамрах хүрээг тодорхойлохоор өмнөх оны 10 судалгаан дээр нэмэлтээр дараах судалгааг хийж байна. Үүнд:<br>• Санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан 2023 он, 2024 оны эхний хагас жилийн мэдээллүүдийг бүрэн шалгасан.<br>• Кайс программаас 2022.07.01-2024.05.01-ний хоорондох хугацааны 445,000 гаалийн бүрдүүлэлтийн бичлэгийг татаж дүн шинжилгээ хийж бодит байдалд бичиг баримттай тулган шалгах хэсгийг ялгасан.<br>• Лабораторийн шинжилгээнд хамрагдах шаардлагатай БТКУС кодтой бараа бүрэн хамрагдсан эсэх талаар кайс программаас мэдээллүүдийг татаж дүн шинжилгээ хийж бодит байдалд бичиг баримттай тулган шалгах хэсгийг ялгасан. | 01.01<br>06.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 7. Хөндлөнгийн байгууллагын хийсэн хэрэглэгчийн үнэлгээний судалгааны дүн /2021 он, 2022 он/.<br><br>- Дотоод аудитын зорилгоор 4 нэгж, 6 ГГХ-ны үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлсон 10 судалгаар хийв. | | | | |
| 4 | Эрсдэлд суурилсан дотоод аудит хийх, холбогдох зөвлөмжийг хүргүүлэх. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1.ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас Захиргаа удирдлагын газар, Боомтын хөгжлийн хэлтсийн 2021, 2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийв.<br>2.Гаалийн байгууллагын "Дотоод аудитын 2023-2025 оны дунд хугацааны төлөвлөгөө"-ний төсөл бэлдэв. | ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас<br>1.Барааны ангилал, үнэлгээний хэлтэс,<br>2.Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар, 2022, 2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийхээр төлөвлөсөн.<br>2.Гаалийн байгууллагын "Дотоод аудитын 2023-2025 оны дунд хугацааны төлөвлөгөө"-ний 2023 оны биелэлтийг гаргана. | - Дотоод аудитын үр дүнгээр өмнөх онд хийгдсэн 10 эрсдэлийн судалгааг 2024 оны эхний хагас жилд хийгдсэн Барааны ангилал үнэлгээний хэлтэс, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитуудад ашиглаж судалгааг хийж ажлын баримтад тусгасан.<br>Сүүлийн хагас жилд хийгдэх Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын үйл ажиллагаанд хийх дотоод аудитын хамрах хүрээг тодорхойлохоор өмнөх оны 10 судалгаан дээр нэмэлтээр дараах судалгааг хийж байна. Үүнд:<br>• Санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан 2023 он, 2024 оны эхний хагас жилийн мэдээллүүдийг бүрэн шалгасан.<br>• Кайс программаас 2022.07.01-2024.05.01-ний хоорондох хугацааны 445,000 гаалийн бүрдүүлэлтийн бичлэгийг татаж дүн шинжилгээ хийж бодит байдалд бичиг баримттай тулган шалгах хэсгийг ялгасан.<br>• Лабораторийн шинжилгээнд хамрагдах шаардлагатай БТКУС | 01.01<br>06.25 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | кодтой бараа бүрэн хамрагдсан эсэх талаар кайс программаас мэдээллүүдийг татаж дүн шинжилгээ хийж бодит байдалд бичиг баримттай тулган шалгах хэсгийг ялгасан. | | |
| 5 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | -МУ-ын Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолын хавсралтад заасан Бодлогын бичиг баримт болох Улсын их хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын биелэлт буюу нийт 11 багц тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн тайланг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн. | Гаалийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлсэн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнана. | - Өмнөх оны 10 удаагийн дотоод аудитын үр дүнгээр өгөгдсөн нийтлэг болон тусгайлсан 259 зөвлөмжийг ЗДАС программаар хүргүүлж улирал, хагас жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр хүргүүлж ирүүлсэн биелэлтийг хянахад 87.85 хувийн биелэлттэй байсан. Эдгээрээс гүйцэтгэлийн үр дүн гартал үргэлжлүүлэх шаардлагатай 35 зөвлөмжийг 2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр хүргүүлсэн. Үүнд: Дотоод аудитын зөвлөмжийн биелэлтэд ОРГГ-96.5 хувь, ГСГГ -91.4 хувь ач холбогдол өгч, тодорхой төлөвлөгөө гарган, зөвлөгөө авч, хамтран ажилласан, БӨГГ -90 хувь, ХОГГ -95 хувь, ГЕГ-ын ЭУХ -81.7 хувь, СШГГ -76.8 хувь үр дүн тооцолгүй, урсгал байдлаар биелэлтийг тайлагнасан байсан. Зөвлөмжийн биелэлтийг эргэн хянасан талаар тайланг ГЕГ-ын Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр газрын удирдлагад танилцуулсан.<br>- 2024 оны эхний хагас жилд БАҮХ-ийн үйл ажиллагаанд 2024.02.23-2024.03.18-ны хооронд хугацаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэн “Сайжруулалт шаардлагатай” дүгнэлт гарч 16 зөвлөмжийг хүргүүлсэн. БДШГ-ын үйл ажиллагаанд 2024.02.23-2024.03.18-ны хооронд хугацаанд хийж гүйцэтгэн “Сайжруулалт шаардлагатай” дүгнэлт | 01.01<br>06.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гарч 23 зөвлөмж, 2 саналыг тус газарт хүргүүлсэн. ХБГ болон ЗТГ-ын үйл ажиллагаанд хийх дотоод аудит 3 дугаар улиралд хийгдэхээр төлөвлөгдсөн.<br>Харьяа гаалийн газар хороодоос СЭГГ-т хийгдэх дотоод аудитын удирдамжийг боловсруулж танилцуулсан болович ГЕГ-ын удирдлагаас хойшлуулсан. Иймд СЭГГ, УХШИГГ, ШХГГ-т хийгдэх дотоод аудитууд 2024 оны сүүлийн хагас жилд хийгдэнэ. | | |
| 6 | Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | 1.МУ-ын Засгийн газрын 2022 оны 374 дүгээр тогтоолын хавсралтад заасан Бодлогын бичиг баримт болох Улсын их хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын биелэлт буюу нийт 11 багц тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв. Үүнд: 24 тогтоол шийдвэрийн биелэлт 86.2 хувь, “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн тайлан 8 зорилт 20 ажлын үнэлгээ 93.1 хувь, | Гаалийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлсэн хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг тайлагнана. | 1.Чиг үүргийн хүрээнд гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг шинэчлэн боловсруулж, ГЕГ-ын даргын 2024.03.27-ны өдрийн А/190 дүгээр тушаалаар батлуулснаар ТӨЛӨВЛӨЛТ+ҮР ДҮНГ үнэлэх арга, аргачлалыг мөрдөх боломж үүссэн. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны “Аргачлал батлах тухай” 143 дугаар тушаал, ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дүгээр тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ын дагуу ГЕГ-ын үйл ажиллагааны үр дүнд ХШҮ хийсэн тайланг жилд 2 удаа Сангийн яаманд хүргүүлж, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллав. Мөн ГЕГ-ын 24 нэгж, харьяа 18 гаалийн газар, хорооны хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны үр дүнд ХШҮ хийж, тайланг Захиргааны зөвлөлд танилцуулан, гүйцэтгэл дутуу болон анхаарах арга хэмжээнүүдийн | 01.01<br>06.25 | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан 100 хувь, Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 2021-2022 оны хэрэгжилт, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт”-ийн тайлан 88.8 хувь, Монгол улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний гаалийн байгууллагын хэрэгжилтийн тайлан 88.8 хувь, Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийн биелэлт 3 үзүүлэлтээр 90 хувь, Хөдөлмөрийн тухай, хүүхдийн эрхийн тухай 2018 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилт 7 ажил 100 хувь, Үйл ажиллагааны ил тод байдлын тайлангийн биелэлт 100 хувь гэж үнэлсэн ХШҮ-ний тайланг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн. | | талаарх зөвлөмжийг хүргүүлэн, гүйцэтгэлийг сайжруулан ажиллаж байна.<br>2.Дотоод аудитын хүрээнд Олон улсын Мэргэжлийн практикийн хүрээнд заагдсан стандартуудыг болон Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, ГЕГ-ын даргын 2020 оны А/256 дугаар тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгэх журам”-ын хэрэгжилтийг хангаж, ГЕГ-ын Барааны ангилал, үнэлгээний хэлтэс, Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газрын үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгэж, нэгжийн эрсдэл, дотоод хяналт, засаглалыг үнэлж, дүгнэн, сайжруулах чиглэлд зөвлөмж хүргүүлэн нэгжийн үнэ цэнийг нэмэгдүүлэн ажиллав. | | |
| 7 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | -- | Нэгжийн:<br>-эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэсэн, | Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар өөрийн нэгжийн үйл ажиллагаанд учирч буй эрсдэлийг тодорхойлж, ГЕГ-ын даргын 2022 оны А/342 дугаар тушаалын хавсралтаар | 01.01<br>06.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | -эрсдэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн, түүний үндсэнд бууруулах арга хэмжээ авсан,<br>-бууруулсан эрсдэлийг санд бүртгэсэн талаар болон нэгжийн үйл ажиллагаанд учирсан ач холбогдол, үр дүнгийн талаар оновчтой тайлагнасан байна. | баталсан журмын хэрэгжилтийг хангах дараах ажлуудыг гүйцэттгэв. Үүнд:<br>1.Байгууллагын эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагааны түвшинд удирдах зорилгоор нэгжийн дарга, ГУАБ, ГУБ нараас асуулга авч, өөрт болон нэгжид учирч буй эрсдэлийн жагсаалтын санг үүсгэв. Жагсаалтаар 18 эрсдэлийг олж тогтоон, хүчин зүйлийг тодорхойлов.<br>2.Дээрх 18 эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн үнэлгээг хийв. Үнэлгээг эрсдэлийн давтамж, нөлөөлөл, үр дагавраар хийж, эрэмбэлэв.<br>3.Эрэмбэлсний үндсэнд эрсдэлийн үнэлгээ өндөр - 2, дунд – 15, бага – 1 нийт 18 эрсдэл байна гэж үзэв. /Хавсралт 1/<br>4.Бага, дунд үнэлэгдсэн 16 эрсдэлийг нэгжийн түвшинд шийдвэрлэх боломжтой гэж үзэн, эхний хагас жилийн туршид ГУБ нарыг чадавхжуулах, өмнөх аудитын явцад дүн шинжилгээ хийх, ГУБ нарын хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулах, улиралд 2 удаа мониторинг хийж, тухайн нэгжийн тухай мэдлэгийг дээшлүүлэх, тухайн нэгжээс зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд оролцох зэргээр ойлголтыг нэмэгдүүлэн ажиллав. Мөн дотоод сүлжээгээр дүгнэх, үнэлэх ажилтай холбоотой мэдээлэл хүргүүлэх, жилийн төлөвлөгөөнд нь мониторинг хийж өгөх зэргээр хамтран ажиллав.<br>5.Өндөр үнэлэгдсэн 2 эрсдэл болох санхүүгийн аудит хийх хүний нөөцгүй болон санхүүгийн аудит гүйцэтгэх чадвар сул гэсэн эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүгийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангуулах хүсэлтийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ГЕГ-ын Хүний нөөцийн хэлтэст уламжилж, асуудлыг шийдвэрлүүлэн, банк-санхүүгийн мэргэжилтэй ГУБ-аар нөхөн хангалт хийлгэв. Тус ГУБ-ийг 4 дүгээр сараас эхлэн дадлагажуулж, өмнөх аудитын үр дүнтэй болон холбогдох хууль, тогтоомжтой танилцуулах ажлыг зохион байгуулав. Мөн дотоод аудиторуудыг санхүүгийн аудит хийх нь сэдэвт сургалтад сүүлийн хагас жилд хамруулахаар төлөвлөж байна. Дотооддоо санхүүгийн аудитын нэг хэсэг болох Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар материал бэлдэн, сургалт явуулж, харьяа гаалийн газар, хороодын ЭБАТ-уудын байршуулсан санхүүгийн мэдээлэлд хяналт шинжилгээ хийж, тайлан бичин Сангийн яаманд хүргүүлэв.<br>- Мөн эрсдэлийн матрицаар хоёрдугаарт өндөр эрсдэлтэй гэж гарсан дотоод аудитын чиглэлээр албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаа байсан. Үүний хүрээнд эрсдэлийг бууруулахын тулд Дотоод аудиторуудын институтийн зохион байгуулдаг “Санхүүгийн дотоод аудит хийх нь сэдэвт” сургалтад хамрагдахаар Гаалийн ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөнд тусгуулан батлуулсан 2024 оны сүүлийн хагас жилд тус сургалтад хамрагдана. | | |
| 8 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Үүрэг даалгаврын биелэлт 97 хувь үнэлэгдсэн. | 1.Үүрэг даалгаврыг бүрэн биелүүлнэ.<br>2.Нэгжээс өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь дүгнэнэ. | 1.Газарт өгсөн 3 ҮД-ыг 98 хувийн биелэлттэй гүйцэтгэв.<br>2. Манай газраас 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар ЗДАС программын үүрэг даалгавар хэсгээр ЗББНДБ-дад 235, харьяа гаалийн газар, хороодод 207 зөвлөмж нийт 519 | 01.01<br>06.25 | 98 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн байна. Эдгээрээс дотоод аудитын үр дүнгээр 77 зөвлөмж өгснөөс 17 зөвлөмжийн хугацаа дуусч хэрэгжилт 96 хувиар үнэлэгдэж ЗДАС программд хассан. Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 442 зөвлөмж өгсөн нь хэрэгжилт дунджаар 81 хувиар үнэлэгдэж ЗДАС программд хаасан байна. | | |
| 9 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Ажлын цаг ашиглалт 100 хувь байсан. | Ажлын цаг ашиглалтыг бүрэн хангана. | 2024 оны 1 дүгээр улиралд 62, 2 дугаар улиралд 63, нийт 125 ажлын өдөр ажиллаж, өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаггүй байв. | 01.01<br>06.25 | 100 |
| 10 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүрэг:<br>ГЕГ-ын даргын 2023 оны А/238 дугаар тушаалыг шинэчлэн боловсруулж батлуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 2023 онд шинэчлэн батлуулсан А/238 дугаар тушаалаар баталсан аргачлалыг гаалийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлэхэд мөрдөв. | Сангийн сайдын 2024 оны 06 дугаар тушаалаар ГЕГ-ын ЗББНДБ-ын чиг үүрэг, бүтцийг шинэчлэн батласны дагуу А/238 дугаар тушаалаар баталсан аргачлалыг өөрчлөн батлуулах | ГЕГ-ын даргын 2024.03.27-ны өдрийн А/190 дүгээр тушаалаар гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлалыг шинэчлэн боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулав. | 01.01<br>06.25 | 100 |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүрэг:<br>Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Нийт 7 ажлын хэсэгт давхардсан тоогоор 8 ГУБ ажиллаж, үүрэг гүйцэтгэсэн. | Энэ онд үүрэг гүйцэтгэхээр томилогдсон Ажлын хэсэгт үр дүнтэй ажиллаж, тайланг ахлагчид өгч нэгтгүүлнэ. | 1.Нэгжийн 3 ГУБ-ид ажлын хэсгийн үүргийг чанартай гүйцэтгэх чиглэл өгөв. | 01.01<br>06.25 | 100 |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүрэг:<br>Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилт, үнэлгээгээр, зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2023 онд 70 хувиар үнэлэгдсэн. | 2024 онд тодорхой хувиар үнэлгээг өсгөх зорилгоор хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах чиглэлийг харьяа ГГХ-дод хүргүүлэх | Нийт 18 гаалийн газар, хорооны дарга нарт Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах тухай албан бичгийг 2024.03.14-ний 01-4/971 тоотоор хүргүүлсний дагуу ГГХ-доос ирүүлсэн төлөвлөгөөнд мониторинг хийв. Төлөвлөгөөний хэрэгжилтийг УБГГ, УХШИГГ, СЭГГ, ЧХОУНБГГ-т очиж танилцан, холбогдох чиглэл, зөвлөмжийг өгч, | 01.01<br>06.25 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | судалгааны үр дүнг сайжруулах урьдчилсан нөхцөлд дүн шинжилгээ хийн ажиллав | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга | Б.Төмөр-Очир / ........................... / | ......... ......... ......... |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ТӨМӨР-ОЧИРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | - | - | • Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан” бэлтгэх сургалтад хамрагдаж эрх авсан. | 05.22-05.24 | 100 |
| 2 | Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” сургалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | - | | • Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 7:4:10 арга зүйн цахим вебинар сургалтад бүрэн хамрагдав. Нийт 13 сургалт тусгай сэдвүүдээр зохион байгуулагдсан. | 01.01-06.10 | 100 |
| 3 | Монгол улсын их сургуулийн хууль зүйн сургуулийн магистрын хөтөлбөрт хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | | | • Монгол улсын их сургуулийн хууль зүйн сургуулийн магистрын хөтөлбөрийн хүрээнд судалгааны ажлыг “Олон улсын эрх зүйн эх сурвалж ба дотоодын эрх зүйн харилцан хамаарал” сэдвээр хийж байна. Сэдвийн хүрээнд судалгаа, гаалийн үйл ажиллагааны ач холбогдолтой эрдэм шинжилгээний хоёр өгүүллийг “Гааль сэтгүүл”, МУИС-ын эрдэм шинжилгээний “Эрх зүй” сэтгүүл, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн редакцид тус тус илгээсэн. | 01.01-06.25 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ............................ /Б.ТӨМӨР-ОЧИР/ 2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БАЯРТОГТОХ ОВОГТОЙ ТӨМӨР-ОЧИРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

### 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 62.4 |

### 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | | 13 |
| 2. | Удирдлагын манлайлал, удирдах арга барилаа сайжруулах чиглэлээр сургалтад хамрагдах | | 13 |
| **Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | | 13 |

### 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 14 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 13 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 13 |
| 4. | Манлайлах | 13 |
| 5. | Багаар ажиллах | 12 |
| 6. | Харилцаа | 14 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | 13 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 13 |

### 4. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 62.4 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 13 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | |
| | **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | 88,4 |

**Үнэлгээ өгсөн:** **Төсвийн шууд захирагч:**

Гаалийн ерөнхий газрын дарга ........................ (Р.Отгонжаргал)

2024.06.19 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

**Нэгжийн дарга:**
Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ (Б.Төмөр-Очир)

2024.06.21 (огноо)